



СОЁМБО

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

№150 /364/

2022.08.24

Цаг үе, үйл явдал

“ДЭЭД БОЛОВСРОЛЫН ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ-ҮБХИС” СЭДЭВТ ЗААХ АРГА ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨН БОЛЛОО



Өнөөдөр “Дээд боловсролын эрх зүйн шинэчлэл-ҮБХИС” сэдэвт заах арга зүйн зөвлөгөөнийг зохион байгуулж байна.

Уг заах арга зүйн зөвлөгөөн нь Монгол Улсын Засгийн газрын “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”,

“ҮБХИС-ийн хөгжлийн стратеги-2030”, Дээд боловсролын салбарын 2022-2023 оны хичээлийн жилийн баримт бичгүүдийн зорилго, зорилтуудад нийцүүлэн багшлах бүрэлдэхүүний мэдлэг, ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх, манлайлах,

хөгжлийн Дээд боловсролын салбарын 2022-2023 оны хичээлийн жилийн баримт бичгүүдийн зорилго, зорилтуудад нийцүүлэн багшлах бүрэлдэхүүний мэдлэг, ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх, манлайлах,

багаар ажиллах арга барилыг дээшлүүлэх, ҮБХИС-ийн 2022-2023 оны хичээлийн жилд үндсэн чиглэлийг тодорхойлох зорилготой юм.

Тус арга хэмжээнд ЗХЖШ-ын Сургалт бэлтгэлийн газрын дарга бригадын генерал Г.Болор, ҮБХИС-ийн захирал бригадын генерал П.Жаргалан,

Батлах хамгаалах удирдлагын академийн захирал бригадын генерал Л.Онцгойбаяр, Цэргийн нэгдсэн дээд сургуулийн захирал бригадын генерал Т.Лодойдамба тэргүүтэй удирдах албан тушаалтнууд, эрдэмтэн багш нар оролцож байна.

“БАГАБАЯН-ЭНХИЙН ТӨЛӨӨ ЦОГЦОЛБОР ТӨВ” БАЙГУУЛАГДСАНЫ 90 ЖИЛИЙН ОЙ ӨНӨӨДӨР ТОХИОЖ БАЙНА



Өнөөдөр буюу 8 дугаар сарын 24-ний өдөр “Багабаян-Энхийн төлөө цогцолбор төв” ТӨААТҮГ-ын хамт олон 90 жилийн ойдоо зориулан хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулж байна. Олон түмэндээ Цэргийн гэх

тодотголоор танигдсан уг байгууллагын хамт олны түүхийн нэгэн шаргал хуудас эргэж байна. Түүхэн тэмдэглэлт, тэгш ойн баярт эл албандаа амьдралаа зориулсан алба хаагчид өргөнөөр хүрэлцэн ирж дурсамж, дурдатгалаа сэргээж, санасан сэтгэлээ дэвтээсэн, баярт мөчөө хуваалцсан үйл явдал боллоо.

Энхийн болон дайны цагт ч үйл ажиллагаагаа явуулсаар ирсэн уг байгууллага өдгөө цогцолбор төв болон өргөжин дэвшиж амрагчдаас гадна хурал, зөвлөгөөн, сургууль дадлагуудыг ихээр зохион байгуулах болсон нь бэлтгэл болон чөлөөнд байгаа ахмадууд, тус ангид ажиллаж байсан офицер, ахлагч, ажилтан албан хаагч болон түүхт 90 жилийн ойгоо хамтдаа бичилцэж буй нийт бие бүрэлдэхүүний гавьяа юм.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 12	🌧️ 2

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 29	🌧️ 23

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3.208	3.215
EUR 🇪🇺	3.215	3.240
CNY 🇨🇳	471	474
RUB 🇷🇺	49.90	50.20
JPY 🇯🇵	23.50	23.70
KRW 🇰🇷	2.39	2.41

ЗУРХАЙ

2022.08.24 /ЛХАГВА ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЫН 27

ЗУНЫ АДАГ УЛААГЧИН ХОНЬ САРЫН НЭГ ЦАГААН ШАРАГЧИН ТАХИА ӨДӨР

Үс засуулбал:

Өлзийтэй сайн

Наран ургах, шингэх: 05.59-19.50

Барилдлага:

Үл зохилдох

Шүтэн барилдлага:

Хурьцахуй

Суудал: Шороо

Энэ өдөр үхэр жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй.

Эл өдөр архи уух, тамхи татах, сэтгэл муутантай нөхөрлөх зэргийг цээрлэх хэрэгтэй ба угаал үйлдэх, хагалгаа хийлгэх, гэр бүрэхэд сайн. Мод суулгах, нарийн зөвлөгөөн хийхэд муу.

Хол газраар яваар одогсод баруун хойд зүгт мөрөө гаргавал зохистой.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 602,590,304

Эдгэрсэн

Нийт: 577,358,183

Нас барсан

Нийт: 6,476,481

"ДӨЛ"-ИЙНХӨН БЭЛТГЭЛЭЭ ЧАМБАЙРУУЛСААР ...

Яг одоо Зэвсэгт хүчний Сургалтын нэгдсэн төвд бороо орж байна. Бороог үл ажран зарим аймаг, нийслэлийн дүүргүүдийн тасгууд бэлтгэлээ чамбайруулсаар байна.

өндөр яваа нь идэвх чармайлт, хичээл зүтгэлээс нь харагдах шиг. Гранат шидэлтийн талбайд Багануур дүүргээс шалгаран оролцож байгаа "Боловсрол" дунд



Дасгалжуулагч нар нь амрахыг санал болгосон ч хүүхдүүд амралтын байрнаасаа дөрөв, таваараа гүйж, хичээлийн цэгүүд дээр очоод гранат

сургуулийн 10, 11 дүгээр ангийн сурагчид болох Б.Дашпүрэв, Э.Тэмүүлэн, Л.Цэнгүүнбат, Ш.Өсөх-Ирээдүй дөрөв байна.



шидэж, буудлагын дасгал гүйцэтгэж эхлэх ажээ. Энэ нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдаж байгаа Батлан хамгаалахын сайдын нэрэмжит улсын аварга шалгаруулах "Дөл-2022" цогцолбор тэмцээнд амжилт дүүрэн оролцох хүсэл тэмүүлэл

Дөрвүүлээ зэрэгцэн гүйж, биеэ халааж, зааварлагчийнхаа тушаалаар нэг нэгээрээ ээлжлэн гранат шидэж, бие биедээ урам бас зөвлөгөө өгнө. Тэдний залгаа Баянхонгор аймгаас ирсэн тасгийн хоёр сурагч охин болох Д.Энхжин, М.Уянга нар гранат шидэж байна.



М.Уянга "Хүсээж мөрөөдөж байсан тэмцээндээ оролцож байгаа болохоор аль болох амжилт үзүүлэхийн тулд хичээж байгаа. Үүний тулд өнөөдөржингөө энд бэлтгэлээ хийж байна. Бид хоёрын шидэлт их ойр буугаад байх юм. Өндөр хөөргөж, хол шидэж сурахын тулд орой хүртэл бэлдэнэ ээ" гэж байна. Бороо бидэнд саад болохгүй, даарахгүй байна гэсээр гранатын талбай руугаа эргээд гүйцээв.



Буудлагын талбайд очлоо. Баян-Өлгий аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга, хурандаа Ц.Буянтогтох нутгаасаа шалгарсан тасгийнхаа залуусыг сургалтын буугаар дасгал гүйцэтгүүлж байв. Тус тасгийнхан Зэвсэгт хүчний 331 дүгээр ангийг түшиглэн 21 хоногийн хугацаанд

бэлтгэлээ чамбайруулжээ. Хурандаа Ц.Буянтогтох даргын хувьд хүүхдүүддээ хэт их ачаалал үүрүүлэхээс татгалзаж байгаа гэнэ. Нутагтаа байхдаа бэлтгэлээ сайн базаасан, одоо зөвхөн орчин нөхцөлд нь дасгаад, бие бялдарт нь тааруулж дасгал хийлгэж байна гэлээ.



Тасгийн хамгийн бяцхан оролцогч нь М.Аружан. Гар бөмбөгөөр хичээллэдэг. Аав, ээж нь охиндоо маш их итгэж үлдсэн, итгэлийг зүтгэлээр хариулах нь түүний хамгийн ойрын мөрөөдөл болжээ. Баян-Өлгий аймгийн тасагтай залгуулаад Дундговь аймаг, нийслэлийн Сүхбаатар дүүргийн шилдэг тасгууд гүйгээд ороод ирлээ. Бороог үл ажран дасгалаа л гүйцэтгэнэ. Зэвсэгт хүчний Сургалтын нэгдсэн төвийн хээрийн байрлал ийм л эрч хүчтэй, цогцолбоотой тамирчин сурагчдаар дүүрэн байна.

Ахлах дэслэгч Д.БОЛОР